



ТӨВ АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 21

Жаргалант сум

2020 онд сум хөгжүүлэх сангаас  
зээл олгох чиглэл батлах тухай

Засаг дарга Т.Цолмонгэрэлийн өргөн барьсан сум хөгжүүлэх сангаас зээл олгох чиглэл батлах тухай саналыг хэлэлцээд “Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангаас 2020 онд төсөл сонгон шалгаруулж, зээл олгох чиглэлийг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан чиглэлийн дагуу төсөл сонгон шалгаруулж зээл олгон зээлийн ашиглалт, эргэн төлөлтийг сайжруулж ажиллахыг сумын Засаг дарга /Т.Цолмонгэрэл/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /П.Ганпүрэв/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.УРАНЧИМЭГ



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2020 оны  
04 дүгээр сарын 02-ны өдрийн 21 дүгээр тогтоолын хавсралт

2020 ОНД СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗЭЭЛИЙН  
ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧИГЛЭЛ

1. Арьс нэхий, ноос ноолуур, боловсруулах цех
2. Хими цэвэрлэгээ, угаалга
3. Эрчимжсэн мал аж ахуй /мах, сүүний/
4. Сүү хөргөлт, тээвэрлэлт
5. Усалгаатай тариалангийн тоног төхөөрөмж

\*\*\*\*\*